



Есдүгээр сар 2017 он

## ӨВЛИЙН НЭГДСЭН ЗУРМАГИЙГ БОЛОВСРУУЛЖ БАТАЛЛАА

Төмөр замын тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын 1.4-т заасныг хэрэгжүүлж, галт тэрэгний хөдөлгөөний 2017-2018 оны өвлийн нэгдсэн зурмагийг боловсруулж 2017 оны 09 дүгээр сарын 29-нд баталлаа. Хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн дагуу галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулан, Төмөр замын тээврийн тухай хууль болон Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журамд заасны дагуу нэгдсэн зурмагийг мөрдөж ажиллахыг суурь бүтэц эзэмшигч нарт мэдэгдсэн.



Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын дагуу хөдөлгөөний нэгдсэн зурмагийг Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг, “Болдтөмөр Ерөө гол” ХХК, “Монголын төмөр зам” ТӨХК-д хүргүүллээ.

## ГАЛТ ТЭРЭГНИЙ ЗУРМАГ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛЖ, НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙВ

Хөдөлгөөн зохицуулалтын төвийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай сайдын тушаалын болон журмын төсөл, саналын товъёо, нөлөөллийн шинжилгээний танилцуулгыг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 2017 оны 09 дүгээр сарын 19-нд хүргүүллээ. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тушаалын төсөл ЗТХЯ дээр хянагдаж байна.

Төмөр замын суурь бүтэц дэх зурмагийг батлуулах хугацаа нь хөдөлгөөний нэгдсэн зурмаг батлуулах хугацаанаас шууд хамаардаг тул үүнээс үүдэн зуны хөдөлгөөний зурмагийг мөрдөж эхлэх хугацаа нь хожимдож байгаа тул “Улаанбаатар төмөр зам” ХНН болон төмөр замын суурь бүтэц эзэмшигч нар нэгдсэн зурмаг боловсруулахад шаардлагатай саналыг Хөдөлгөөн зохицуулалтын төвд ирүүлэх хугацааны цагалбарт өөрчлөлт оруулж, түүнд нийцүүлэн галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг боловсруулах болон батлуулах цагалбарыг бодит нөхцөлд нийцүүлэн өөрчлөх зайлшгүй шаардлага үүссэн.

Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн цаглабарыг бодитой болгох, мөн энэхүү журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага болон гомдол гаргах харилцааны зохицуулалтыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх зорилготой юм.

Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулсанаар журмыг зөрчсөн болон мөрдөөгүйгээс хохирол учруулсан, мөн зурмагийн биелэлтэд буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, журмын хэрэгжилтэд хяналт тавих этгээд, гомдол гаргах харилцаа нь тодорхой, захиргааны ерөнхий хуульд нийцсэн зохицуулалт болж чадах ба харин суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг тогтоосон журмаар батлах, хөдөлгөөний нэгдсэн зурмагт санал ирүүлэх, хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн дагуу өөрийн эзэмшлийн суурь бүтцийн үйлчилгээний хүрээнд галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах, хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэх эрх нь суурь бүтэц эзэмшигчид хэвээр үлдэнэ.



Есдүгээр сар 2017 он

## **ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГТ ОРЖ АЖИЛЛАЖ БАЙНА**

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 115 дугаар тушаалаар байгуулагдсан Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг 2017 оны 09 дүгээр сарын 15-нд Тээврийн дээд сургуулийн багш, ажилтнуудын санал, хүсэлтийг сонсох уулзалт арга хэмжээ зохион байгуулж, Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайланг танилцууллаа. Уг арга хэмжээнд ажлын хэсгийн гишүүн, төвийн 3 төлөөлөл оролцож саналаа илэрхийлж ажиллалаа.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахтай холбогдуулан Хөдөлгөөн зохицуулалтын төвийн чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааг шинэчлэн тодорхойлж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

## **СУУРЬ БҮТЭЦ ХООРОНД ГАЛТ ТЭРЭГ СОЛИЛЦОХ ТЕХНОЛОГИЙН ГОРИМ БОЛОВСРУУЛАХААР АЖИЛЛАЖ БАЙНА**

Төвийн 2017 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний 1.2-т тусгагдсан “УБТЗ” ХНН, “БТЕГ” ХХК, “МТЗ” ТӨХК-ийн суурь бүтэц хооронд галт тэрэг солилцох технологийн горим боловсруулах” ажлын хүрээнд “УБТЗ” ХНН-ийн Сүхбаатар хэсэглэл дэх Ерөө өртөө, “БТЕГ” ХХК-ийн Цагаанхаалга, Хандгайт өртөө, “МТЗ” ТӨХК-ийн Төмөртэй өртөөнд тус тус ажиллаж технологийн үйл ажиллагаатай танилцсанаар суурь бүтцүүдийн хооронд галт тэрэг солилцох технологийн үйл ажиллагаатай биет байдал дээр нь танилцлаа.



## **ТӨМӨР ЗАМЫН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

Төмөр замын салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн хурлыг 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгууллаа. Хурлаар Монголын мэргэшсэн зөвлөх инженерүүдийн холбооноос зохион байгуулсан “Мэргэшсэн, зөвлөх инженер”-ийн зэрэг олгох, сунгах сургалтад хамрагдсан зэрэг горилоч нарын мэргэжлийн шалгалтын болон тайлан хамгаалалтын дүнг хэлэлцэж, зөвлөх болон мэргэшсэн инженерийн зэрэг горилочдод тавигдах шаардлага хангасан инженерүүдийн мэргэжлийн зэрэг олгох, сунгах асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох шийдвэрийн төслийг албан бичгээр ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т хүргүүлэв.



Есдүгээр сар 2017 он

## АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Төвийн Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөний дагуу “Дэлхийн зарим улс орнуудын авлигатай тэмцэх үйл ажиллагаа” сэдэвт сургалтыг ажилтнуудын дунд зохион байгуулсан. Тус сургалтын хүрээнд Сингапур, Дани, Швед, Хонг Конг улсуудын авлигатай хэрхэн тэмцэж ирсэн түүхэн туршлага мөн өнөө цагт хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн талаар мэдээлэл өгсөн. Хүн болгон хуулиа дээдэлж, аливаа ажил үүргээ шударга хийж гүйцэтгэснээр ирээдүй, хойч үедээ шударга, хүмүүнлэг нийгмийг үлдээж, улс эх орныхоо цаашдын хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулах болно.



## ЖИЛ БҮР ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ ЦАХИМ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УУЛЗАЛТ СУРГАЛТ СЕМИНАРТ ХАМРАГДЛАА

Цахим аюулгүй байдлын чиглэлээр олон улсын болон дотоодын мэргэжилтнүүдтэй мэдээлэл, мэдлэг чадвараа солилцох, арга туршлагаа хуваалцах, шинэ шийдэл, технологитой танилцах боломжуудыг хамруулсан “MNSEC 2017” уулзалт семинарт 9 дүгээр сарын 28-ны өдөр хамрагдсан.

## “ICT-EXPO-2017” МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦЛОО

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас 11 дэх удаагаа зохион байгуулж буй “ICT-Expo-2017” мэдээллийн технологийн үзэсгэлэнд 2017 оны 09 дүгээр сарын 15-нд оролцож Харилцаа холбооны зохицуулах хороо, Нийслэлийн мэдээлэл, технологийн газар, “Монпасс” ХХК нарын мэргэжилтнүүдтэй уулзаж төрийн байгууллагуудын цахим гарын үсгийг хэрхэн олгож буй талаар мэдээлэл авч, хамтран ажиллахаар тохиролцсон.





Есдүгээр сар 2017 он

## ОЛОН УЛСЫН ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВҮҮДИЙН СУДАЛГАА

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв” УТҮГ-аас төмөр замын тээврийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор өндөр хөгжилтэй улс орнуудын галт тэрэгний хөдөлгөөн удирдлагын төвийн үйл ажиллагаа болон техник технологийн шийдлийг харьцуулан судалж, тухайн улсын төмөр замын тээврийн бодлогын баримт бичгийг орчуулан боловсруулж байна.

### БНХАУ-ЫН БЭЭЖИН ДАХ ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАХ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

БНХАУ-ын төмөр замын хөдөлгөөний хяналтын төв нь Бээжин хот, Шанхай хот, Гуанжоу хотод тус тус байрладаг, 11 хяналт удирдлагын төвтэй. Төвүүдийг тус бүр Сингапур улсын ST Engineering Ltd компани, CASCO компани тус тус гүйцэтгэсэн бөгөөд засгийн газрын харилцан ажиллах гэрээнд тулгуурлан бүтээгджээ. Бээжингийн төмөр замын газрын Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах төвийн танхим нь одоогоор Азийн хамгийн том буюу 4050 м<sup>2</sup> талбайтай эзэлдэг.

Гол зохицуулалт нь Бээжин-Шанхай, Бээжин-Гуанжоу, Тяньжин-Чинхуандао, Бээжин-Тианжин мөн 17 чиглэлийн галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулдаг. Удирдлага, хяналтын төвийн өрөөний хэв маяг нь театр шиг бөгөөд дэлгэцээр галт тэрэгний хөдөлгөөний зурмаг, бүдүүвч шугамын станц болон суурь мэдээллийг цаг алдалгүй тухай бүрт нь харж хянадаг.

Бээжингийн галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах төвийн харьяалалд Бээжин, Тианжин, Хэбэй, Шандон, Шанси мужууд ордод ба Тайюан, Хөх хот, Жөнжоу, Жинань, Шеняан зэрэг 5 төмөр замын байгууллагатай холбогдож 7671.5км замын үйл ажиллагааг хянадаг байна.



Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах төв нь 712 диспетчертэй, дундаж нас 40, нийт 80 диспетчерийн ширээтэй бөгөөд галт тэрэгний хөдөлгөөн, зүтгүүр, барилга, зорчигч тээвэр, цахилгаан, тээврийн хэрэгсэл, статистик, дүн шинжилгээ зэрэг 17 төрлийн диспетчерээс бүрдэнэ. Өдөр бүр өглөө 7 цагаас орой 19 цаг хүртэл үндсэн ажлын цаг бөгөөд бүх диспетчерүүд өдрийн тайлангаа өгнө. Диспетчер нь ажлын 12 цагаар ажиллаж өдөр шөнийн 2 ээлжтэй байдаг. Нэг диспетчерийн ширээ ихдээ 22, багадаа 8 дэлгэц хосолсон байдаг ба диспетчерийн ширээ нь нэг чиглэл хариуцан ажилладаг байна.

## ТЭЭВЭРЛЭЛТИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ



Зорчигч тээвэрлэлт 2017 оны есдүгээр сард 194.9 мян.зор тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 4.3%-аар өссөн, ачаа тээвэрлэлт нь 2017 оны есдүгээр сард 2020,6 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.8%-аар өссөн үзүүлэлттэй байна.



2017 оны нэгээс есөн сард ачилт 12036.5 мян.тн өмнөх оны мөн үетэй харьцуулбал 11.9% өссөн, есдүгээр сард ачилт 1592.5 мян.тн буюу өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9.3% өссөн үзүүлэлттэй байна.



Дамжин өнгөрсөн ачаа 2017 оны есдүгээр сард 230393.7 тн ачсан нь өнгөрсөн оны мөн үеэс 44649.1 тн буюу 24 хувиар өссөн байна.